



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/293

Сүхбаатар сум

### Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", 30 дугаар зүйлийн 30.1.17. Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.6, 9.3.13 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хог хаягдлын тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, "Хоггүй, цэвэрхэн Монгол" аяны хүрээнд аймгийн хэмжээнд бүх нийтийн цэвэрлэгээг 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсугай.

2.Бүх нийтийн цэвэрлэгээний өдөр орчныхоо хог хаягдлыг цэвэрлэх, үйл ажиллагаанд ажилтан, албан хаагч, иргэд, айл өрхийг хамруулан, идэвхтэй оролцохыг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, сууц өмчлөгчдийн хэлбоо, аж ахуйн нэгж байгууллагуудад үүрэг болгосугай.

3.Аяны хүрээнд бүх нийтийн цэвэрлэгээг сум, орон нутагтаа зохион байгуулж, хийж гүйцэтгэсэн ажлын тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2020 оны 10 дугаар сарын 23-ний дотор ирүүлэхийг сумын Засаг дарга нарт даалгасугай.

4.Бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /А.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ